

ДЭЛХИЙН РАДИОГИЙН ИХ ХУРАЛД ОРОЛЦСОН ТУХАЙ

ОУЦХБ-ын радио холбооны дээд хэмжээний уулзалт ДРИХ (Дэлхийн радиогийн их хурал) нь 4 жилд нэг удаа зохион байгуулагдаж дэлхийн радиогийн дүрэмд өөрчлөлт оруулдаг. Энэ удаагийн хуралдаан 2023 оны 11-р сарын 20-ноос 12-р сарын 15 –ны өдрүүдэд Арабын Нэгдсэн Емират Улсын Дубай хотод зохион байгуулагдаж 151 улсын 4000 гаруй төлөөлөгч оролцлоо. Монгол Улсаас ЦХХХЯ-ны Сансар радиогийн хэлтсийн ахлах шинжээч С.Онончимэг, ХХЗХ-ны ажлын Албаны дарга А.Лувсан-Очир, РДЗХГ-ын дарга З.Амгалан, ахлах мэргэжилтэн Ч.Тэрбиш, ахлах мэргэжилтэн А.Болортуяа, мэргэжилтэн Ц.Батхүү нар төлөөлөн оролцож дараах ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:

1. Радио давтамжийн 3300-3400МГц зурвас нь бүс нутгийн хуваарилалтын дагуу манай улс Радиолокацын үйлчилгээ эрхлэх байсныг өөрчилж ДҮХХ (дараа үеийн хөдөлгөөнт холбоо) ашиглах тусгай заалт оруулах саналыг хэлэлцүүлэхэд хөрш орнууд манай саналын эсрэг байр суурь илэрхийлсэн бөгөөд тусгайлсан хэлэлцээрүүдийг хийснээр радиогийн дүрмийн 5.429В заалтаар Монгол Улсад энэ зурвасыг хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглахаар батлууллаа.
2. Радио давтамжийн 3600-3800МГц зурвасыг хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд хуваарилуулах асуудал нэлээд ширүүн мэтгэлцээнтэй явагдсан бөгөөд хуралдааны явцад хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглах орнууд радиогийн дүрмийн 9.21, 9.17.9.18 заалтуудыг дагаж мөрдөж хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд энэ зурвасыг ашиглаж болох шинэ заалтыг батлуулсан.
3. Радио давтамжийн 76-87.5МГц зурвасыг ФМ өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд ашиглахаар дэлхийн радиогийн дүрмийн 5.175 заалтад Монгол Улсын нэрийг оруулах санал өгөхөд ОХУ, Хятад улсууд эсэргүүцсэн бөгөөд тусгайлан уулзаж, тухайн заалтад эдгээр улсуудын радио холбооны үйлчилгээнд харилцан нөлөөлөл үүсгэхгүй байх нөхцөлүүдийг тусгуулах талаар дахин манай талаас хуралдааны явцад санал өгч ажилласнаар манай улсад энэ зурваст ФМ үйлчилгээг хэрэгжүүлэх боломжтой болж батлагдав.
4. Радио давтамжийн 21850-21870 кГц; 8500-8750 МГц зурвасуудыг радиогийн дүрмийн 5.155, 5.469 заалтуудаас хасуулах саналуудыг танилцуулж хасалт хийгдэж батлуулсан ба харин радио давтамжийн 21850-21870 кГц зурвасыг 5.155А хасуулах саналд ОХУ болон RCC байгууллага эсрэг байр суурь илэрхийлсэн. 12-р сарын 1-ний өдөр тус талуудын төлөөллүүдтэй уулзаж тохиролцоонд хүрснээр батлагдсан болно.



